

БАГА ХЭМЖЭЭНИЙ ЦӨМИЙН МАТЕРИАЛЫН ШИНЭЧИЛСЭН ПРОТОКОЛЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫН УРЬДЧИЛСАН ТАНДАН СУДАЛГАА

УДИРТГАЛ

ОУАЭА-ийн цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааны хяналт нь цөмийн зэвсэг тархааас сэргийлэх зорилготой олон улсын цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх дэглэмийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг юм. Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай гэрээ (ЦЗҮДГ) нь цөмийн зэвсэггүй бүх улс орнуудыг Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА)-тай Иж бүрэн баталгааны гэрээ (ИББГ) байгуулахыг шаарддаг. Үүний нэгэн адил бүх Цөмийн зэвсэггүй бусийн тухай гэрээнүүд нь улс орнуудыг ОУАЭА-тай ИББГ-г байгуулахыг шаарддаг. ИББГ-ний дагуу ОУАЭА нь тухайн улсын нутаг дэвсгэр болон харьяаллын хүрээнд буюу хяналтад байгаа цөмийн технологийн энхийн хэрэглээнд ашиглагдаж буй бүх эх үүсвэр материал болон тусгай хуваагдах материалыг цөмийн зэвсэг болон бусад цөмийн тэсрэх төхөөрөмжид ашиглагдаагүйг шалгах зорилгоор цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгаа хэрэглэж, баталгаажуулах эрх, үүрэгтэй. Иймд ОУАЭА нь ИББГ-ний дагуу улс орнуудын мэдүүлгийн үнэн зөв, бүрэн байдлыг шалгах эрх мэдэлтэй бөгөөд ингэснээр мэдүүлсэн цөмийн материалыг тухайн мэдүүлсэн үйл ажиллагаанаас өөр зорилгоор ашиглуулахгүй, шилжүүлэхгүй байх, мөн мэдүүлээгүй цөмийн материал, үйл ажиллагаа байхгүй гэсэн найдвартай баталгааг бий болгож, дүгнэлт гаргадаг.

1970-аад оны эхэн үеэс ИББГ-нд тодорхойлсны дагуу бага хэмжээний цөмийн материалтай эсвэл огт цөмийн материалгүй улс орнууд болон байгууламждаа цөмийн материалгүй улс орнууд ИББГ-ний Бага хэмжээний цөмийн материалын протоколд нэгдэх боломжтой болсон. БХЦМП нь улс орнуудад баталгааны хэрэгжилтийн дарамтыг багасгаж өгсөн. БХЦМП нь ИББГ-ний тайлгнах болон хяналт шалгалт хийхтэй холбоотой ихэнх заалтууд үйлчлэхгүй байх зохицуулалтыг бий болгосон.

2005 онд ОУАЭА-ийн Захирлуудын зөвлөлөөс БХЦМП-ын анхны хувилбарыг шинэчлэх, БХЦМП-д хамрагдах шалгуурт өөрчлөлт оруулахыг зөвшөөрснөөр одоо байгаа эсвэл төлөвлөж буй байгууламжтай улс орнуудад протоколыг хэрэглэх боломжгүй болгосон. Захирлуудын зөвлөл нь ОУАЭА-ийн Ерөнхий захиралд шинэчилсэн хувилбарыг болон өөрчилсөн шалгуурыг хэрэгжүүлэх, БХЦМП-ын дагуу бүх улс орнуудтай захидал солилцохыг зөвшөөрч, холбогдох улс орнуудад захидал солилцох ажлыг аль болох хурдан хугацаанд хангахыг 2005 онд уриалсан.

Монгол Улс Иж бүрэн цөмийн аюулгүй байдлын баталгааны гэрээнд (Comprehensive Safeguards Agreement) 1972 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр нэгдэн орсон. Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээний баталгааг хэрэглэх тухай Нэмэлт протоколд Монгол Улс нэгдэн орж, 2001 оны 12 дугаар сард гарын үсэг зурсан бөгөөд Улсын Их Хурал 2003 онд соёрхон баталж, Олон улсын атомын энергийн

агентлагт 2003 оны 05 дугаар сарын 12-ны өдөр мэдэгдэж, энэ өдрөөс протоколыг хүчин төгөлдөр мөрдөж байна.

Иж бүрэн баталгааны гэрээ (ИББ) нь заавал дагаж, мөрдөх гэрээ бөгөөд гэрээний хүрээнд цөмийн материалыг цөмийн зэвсэг эсвэл бусад тэсрэх төхөөрөмжид ашиглахгүй байх, цөмийн төхөөрөмжтэй болон төхөөрөмжгүй улсууд адил шаардлагын дагуу цөмийн материалын бүртгэл, хяналтын тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, Олон улсын атомын энергийн агентлагт тайлан, мэдэгдэл хүргүүлэх зэрэг үүрэг хүлээдэг.

Бага хэмжээний цөмийн материалын протокол нь бага хэмжээний цөмийн материалтай эсвэл огт цөмийн материалгүй улс орнууд болон байгууламждаа цөмийн материалгүй улс орнуудад зориулан 1970-аад онд гаргасан эрх зүйн баримт бичиг юм. Шинэчилсэн протокол нь ОУАЭА-ийн баталгааны гэрээний үндсэн заалтуудын хэрэгжилтийг хангах, ОУАЭА-аас тухайн улсын хууль тогтоомж, хяналт дор буй цөмийн материалыг баталгаажуулах талаар илүү их мэдээлэл өгөх боломжийг олгодог. Улс орон бүх цөмийн материалын анхны тайлангаа ОУАЭА-т хүргүүлэх шаардлагатай байдаг.

2005 онд Захирлуудын зөвлөлийн шийдвэр гарснаас хойш багагүй хугацаа өнгөрснийг харгалзан ОУАЭА нь Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколын анхны хувилбарт суурилсан байгаа улс орнуудад баталгааны дүгнэлтийг үргэлжлүүлэн гаргах боломжгүйг мэдэгдсэн. Монгол Улсын хувьд зохих арга хэмжээ авахгүй тохиолдолд 2024 оноос баталгааны дүгнэлт гаргах боломжгүй болохыг мэдэгдсэн.

Монгол Улсын Их Хурлын 2009 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 45 дугаар тогтоолын хавсралт, Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого 7.4-т зааснаар Цөмийн болон цацрагийн аюулгүй байдалтай холбогдсон олон улсын гэрээ, конвенц, хэлэлцээр, протоколын биелэлтийг хангах, шаардлагатай гэрээ конвенцод нэгдэн орох асуудлыг шийдвэрлэнэ гэж заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2015 оны “Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай” 60 дугаар тогтоолд Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орохыг Засгийн газарт даалгасан.

Улсын Их Хурлын 60 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэх талаар хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр шийдвэрлэсэн. Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар уг конвенцод нэгдэн орох асуудлыг хэлэлцэн дэмжсэн.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орох хэрэгцээ, шаардлагын талаарх урьдчилан тандан судалгааг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. АСУУДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эрүүл мэнд, аж үйлдвэрийн салбарт цацраг идэвхт үүсгүүрийн хэрэглээ нэмэгдэж байгаатай холбогдуулан олон улс орон өөрийн нутаг дэвсгэрт цөмийн материалтай болох магадлал нэмэгдэж байна. Цөмийн материалын эрүүл мэндийн салбар дахь түгээмэл хэрэглээ нь хавдрын зайн туяа эмчилгээ зэрэг цацрагийн эмчилгээний тоног төхөөрөмжийн цацрагийн хамгаалалтад ядуурсан ураныг ашиглах явдал юм. Цөмийн материал нь мөн аж үйлдвэр, судалгаа шинжилгээний зорилгоор ашиглагддаг.

Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг хүрээнд өөрийн онцлог, нөхцөл байдалд тохирсон цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааг хэрэгжүүлэх, улмаар цөмийн материалын ашиглалт, хэрэглээнд үр дүнтэй хяналт тавих, цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааг гүйцэтгэх, хянах техникийн чадавхыг бэхжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, цөмийн материалын хяналтын тооллогын улсын системийг бий болгох шаардлагатай байна.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээ

Бага хэмжээний цөмийн материалын протоколын анхны хувилбарын зарим хийдлүүдийг арилгах үүднээс цөмийн байгууламжгүй, бага хэмжээний цөмийн материалын протоколтой улс орнуудад зориулан ОУАЭА нь 1974 онд баталсан Бага хэмжээний цөмийн материалын протоколын анхны хувилбарыг 2005 онд шинэчилсэн.

ОУАЭА-ийн Захирлуудын зөвлөл нь Ерөнхий захиралд шинэчилсэн хувилбар, түүний шалгуурыг хэрэгжүүлэх, Бага хэмжээний цөмийн материалын протоколын дагуу бүх улс орнуутдай захидал солилцохыг зөвшөөрч, холбогдох улс орнуудад Бага хэмжээний цөмийн материалын протоколын шинэчилсэн хувилбарыг авч хэрэгжүүлэхийг уриалсан захидал илгээсэн.

ОУАЭА-аас 2005 онд гаргасан Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орох уриалгын дагуу 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар 63 улс протоколын шинэчилсэн хувилбарыг даган мөрдөж байна.

№	Нийгмийн бүлэг	Эрх ашиг, сонирхолд нөлөөлөх хэлбэр
1.	БХЦМП-ын шинэчилсэн протоколын анхны хувилбарыг шинэчилсэн улс орнууд	Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколын хүрээнд өөрийн орны онцлог, нөхцөл байдалд тохирсон цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааг хэрэгжүүлэх, улмаар цөмийн материалын ашиглалт, хэрэглээнд үр дүнтэй хяналт тавих, цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааг гүйцэтгэх, хянах техникийн чадавхыг бэхжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, цөмийн материалын хяналтын тооллогын улсын системийг бий болгож бүх цөмийн материалыг энхийн үйл ажиллагаанд зориулж буйг дүгнэсэн өргөн хэмжээний дүгнэлтийг гаргуулна.
2.	БХЦМП-ын анхны хувилбарыг шинэчлээгүй улс орнууд	Өөрийн орны онцлог, нөхцөл байдалд тохирсон цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэхгүй. Цөмийн материалын ашиглалт, хэрэглээнд үр дүнтэй хяналт тавих, техникийн чадавхыг бэхжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр ОУАЭА-аас авах тусlamж дэмжлэг царцах эрсдэлтэйгээс гадна цөмийн материалыг энхийн үйл ажиллагаанд зориулж буйг дүгнэсэн өргөн хэмжээний дүгнэлтийг ОУАЭА-аас гаргах боломжгүй нөхцөл байдал үүсээд байна. Энэ нь Монгол Улсын нэр хүнд ОУАЭА-т буурах, ОУАЭА-аас Монгол Улсад хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, авч буй дэмжлэг, тусlamжийг царцаах сөрөг үр дагавар үүсээд байна.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

1970-аад оны эхэн үеэс Иж бүрэн баталгааны гэрээ (ИББГ)-нд тодорхойлсны дагуу бага хэмжээний цөмийн материалтай эсвэл огт цөмийн материалгүй улс орнууд болон байгууламждаа цөмийн материалгүй улс орнууд ИББГ-ний Бага хэмжээний цөмийн материалын протоколд нэгдэх боломжтой болсон.

БХЦМП нь улс орнуудад баталгааны хэрэгжилтийн дарамтыг багасгаж өгсөн. БХЦМП нь ИББГ-ний тайллагнах болон хяналт шалгалт хийхтэй холбоотой ихэнх заалтууд үйлчлэхгүй байх зохицуулалтыг бий болгосон. 2005 онд Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА)-ийн Захирлуудын зөвлөлөөс БХЦМП-ын анхны стандарт текстийг шинэчлэх, БХЦМП-д хамрагдах шалгуурт өөрчлөлт оруулахыг зөвшөөрснөөр одоо байгаа эсвэл төлөвлөж буй байгууламжтай улс орнуудад протоколыг хэрэглэх боломжгүй болгосон. Захирлуудын зөвлөл нь ОУАЭА-ийн Ерөнхий захиралд шинэчилсэн стандартчилсан текст болон өөрчилсөн шалгуурыг хэрэгжүүлэх, БХЦМП-ын дагуу бүх улс орнуудтай захидал солилцохыг зөвшөөрч, холбогдох улс орнуудад захидал солилцох ажлыг аль болох хурдан хугацаанд хангахыг уриалсан.

Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА)-ийн Удирдах зөвлөлөөс цөмийн байгууламжгүй, бага хэмжээний цөмийн материалтай улс орнуудад “Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протокол”-д хамрагдах нь тохиромжтой гэж үзэн гишүүн орнуудыг элсэн орохыг уриалсан. Үүний дагуу ОУАЭА-аас манай улсыг Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орох уриалгыг анх 2005 онд ирүүлснээс хойш 2020, 2021, 2022, 2024 онуудад ирүүлсэн чөнөөдрийг хүртэл энэ асуудал шийдвэрлэгдээгүй байна.

ОУАЭА-ийн Ерөнхий захирлын орлогч бөгөөд Баталгааны газрын захирал Массимо Апарогийн хүснэгтийн дагуу Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суугаа Элчин сайд М.Цэнгэг 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр уулзалт хийсэн. 2005 онд ОУАЭА-ийн Захирлуудын зөвлөлийн шийдвэр гарснаас хойш багагүй хүргээс өнөөдөрсийг хялгаплан ОУАЭА нь Бага хэмжээний цөмийн материалын

протоколын анхны хувилбартай байгаа улс орнуудад баталгааны дүгнэлтийг үргэлжлүүлэн гаргах боломжгүй мэдэгдсэн. Монгол Улсын хувьд зохих арга хэмжээ авахгүй тохиолдолд 2024 оноос баталгааны дүгнэлт гаргах боломжгүй болохыг мэдэгдсэн.

Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотод 2024 оны 9 дүгээр сарын 16-20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ОУАЭА-ийн Ерөнхий бага хурлын ээлжит 68 дугаар чуулганаар Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх баталгааны газраас гаргасан хүсэлтийн дагуу манай улсын төлөөлөгчид уулзалт хийсэн. ОУАЭА-аас Монгол Улсыг Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн ороогүй цөөн орны тоонд багтсан бөгөөд протоколыг даруй шинэчлэх шаардлагатайг дахин анхааруулж, 2024 ондоо багтаан протоколыг шинэчлэх шаардлагатайг мэдэгдсэний дагуу Монгол Улсын Цөмийн энергийн комисст захидал хүргүүлэхээр болсон.

Улмаар ОУАЭА-ийн Ерөнхий захирлын орлогч бөгөөд Баталгааны газрын дарга Массимо Аппарогийн 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн албан захидалыг Цөмийн энергийн комиссын дарга, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваанд ирүүлсэн. Тус захидалд ОУАЭА нь Бага хэмжээний цөмийн материалын протоколын анхны хувилбартай байгаа улс орнуудад баталгааны дүгнэлтийг үргэлжлүүлэн гаргах боломжгүй мэдэгдэж, Монгол Улсын Засгийн газар зохих арга хэмжээ авахгүй тохиолдолд 2024 оноос баталгааны дүгнэлт гаргах боломжгүй болохыг мэдэгдсэн. Энэ нь Монгол Улсын нэр хүнд ОУАЭА-т буурах, ОУАЭА-аас Монгол Улсад хэрэгжүүлж буй тесөл, хөтөлбөр, авч буй дэмжлэг, тусlamжийг царцаах сөрөг үр дагавар үүсээд байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫН ТОМЬЁОЛОЛ

- Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх зорилтуудыг дэмжих (Монгол Улсад ашиглагдаж буй бүх цөмийн материалыг энхийн үйл ажиллагаанд ашиглаж буйг ОУАЭА-аас баталгаажуулан, нэгдсэн дүгнэлтийг гаргуулах);
- Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусыг бэхжүүлэх;
- Монгол Улс дахь ОУАЭА-ийн баталгааны хяналтыг сайжруулах (хяналт шалгалт);
- Монгол Улс цөмийн төхөөрөмжгүй бөгөөд бага хэмжээний цөмийн материалтай улсын хувьд Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орсноор өөрийн улсын онцлог, нөхцөл байдалд тохирсон цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааг хэрэгжүүлэх;
- Цөмийн материалын хяналтын тооллогын улсын системийг бий болгох;
- Цөмийн материалын ашиглалт, хэрэглээнд үр дүнтэй хяналт тавих, цөмийн баталгааг гүйцэтгэх, хянах чадавхийг бий болгох;
- ОУАЭА-ийн Техникийн чадавхыг бэхжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах;
- ОУАЭА-ийн зөвлөх үйлчилгээ авах, дадлагажуулах хөтөлбөрт хамрагдах зэрэг болно.

Иймд дээрх асуудлыг шийдвэрлэх зорилго нь “Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протокол”-д нэгдэн орох явдал юм.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ, ХУВИЛБАР, ЭЕРЭГ СӨРӨГ ТАЛ

Асуудлыг шийдвэрлэх, зорилгын биелүүлэхэд чиглэсэн зохицуулалтын хувилбаруудыг тогтоож, зардал үр өгөөжийн харьцаа, эерэг болон сөрөг талыг дараах байдлаар гаргав.

д/д	Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Эерэг сөрөг тал	Зардал, үр өгөөжийн харьцаа
1.	Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Одоогийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Үр дүн сөрөг	Ямар нэг зардал гаргахгүй. Үр дүн ашиг муутай.
2.	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Асуудлыг шийдвэрлэхэд зохих хэмжээгээр түлхэц үзүүлэх хэдий ч зорилгод хүрч чадахгүй.	Үр дүн сөрөг	Бага хэмжээний зардал гарна. Үр дүн тодорхой хэмжээний ахиц дэвшил гарна.
3.	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Энэ хувилбарыг ашиглах тохиолдолд зорилгод хүрэх боломжгүй.	Үр дүн сөрөг	Тодорхой хэмжээний зардал шаардагдана. Үр ашиггүй.
4.	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Төр зөвхөн санхүүгийн дэмжлэг, үзүүлснээр биелэхгүй.	Үр дүн сөрөг	Их хэмжээний зардал гарна. Үр ашиг муутай.
5.	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үргийг гүйцэтгүүлэх	Тодорхой ажиллагаанд үйл тэдний оролцоо, хамтын ажиллагаа ач холбогдолтой боловч шийдвэр гаргах түвшинд зорилго хангагдахгүй.	Үр дүн сөрөг	Их хэмжээний зардал гарна. Үр ашиг муутай.
6.	Захиргааны шийдвэр гаргах	Гадаад орон, олон улс хоорондын харилцааг шууд зохицуулж чадахгүй бөгөөд дотоод шинж чанартай зарим асуудлыг шийдвэрлэнэ.	Үр дүн сөрөг	Тодорхой хэмжээний зардал гарна. Үр ашиг муутай.
7.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	“Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протокол”-ийг соёрхон баталснаар зорилгодоо хурнэ.	Үр дүн Эрэг	Зардал гарахгүй. Үр ашигтай.

Эрэг сөрөг тал:

Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орохтой холбоотой асуудлыг 2016 онд Засгийн газар, УИХ-ын Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар тус тус хэлэлцүүлж, тогтоол шийдвэрүүд гарч байсан. Гэвч цөмийн энергийн салбарын олон улсын эрх зүйн баримт бичгийн төслийн буруу ташсээ сийгээгүй звиж, мэдээ, мэдээлэл путмаг байсан учраас иргэний

нийгмийн байгууллагууд эсэргүүцэх, нэгдэхгүй байхыг уриалах зэрэг асуудлууд гарч, хуулийн төсөл УИХ-аар хэлэлцэгдэлгүй буцаагдаж байсан.

Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх хувилбарыг ашиглаж, конвенц, протоколд нэгдэн орохтой холбоотой асуудал болон олон нийтийн цөмийн энергийн салбарын олон улсын хууль эрх зүйн баримт бичгүүдийн талаар сурчилан танилцуулах зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ), Гадаад харилцааны яам (ГХЯ), Цөмийн энергийн комисс, Олон Улсын Атомын Энергийн Агентлагтай хамтран “Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгаа, цөмийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны олон улсын эрх зүйн хэрэгсэл” сэдэвт өндөр тувшиний зөвлөгөөн “Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх баталгаа, цөмийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны холбогдолтой олон улсын конвенц, протоколд нэгдэн орохыг дэмжих нь” сэдэвт үндэсний хэлэлцүүлгийг 2023 оны 06 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсан.

Тус үйл ажиллагаанд ОУАЭА-ийн Хууль, эрх зүйн газар, Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааны газар, Цөмийн аюулгүй байдлын хэлтэс, Цөмийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын газар, Цацрагийн үүсгүүр, тээвэрлэлт, хаягдлын аюулгүй ажиллагааны хэлтэс, Цөмийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын газар, Монгол Улсын Ерөнхий сайдын төлөөлөл, Улсын Их хурлын гишүүд, УИХ-ын гишүүдийн төлөөлөлөгч, УИХ-ын Тамгын газар, УАБЗ-ийн Стратегийн хэлтэс, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Гадаад харилцааны яам, Боловсрол соёл шинжлэх ухааны яам, Батлан хамгаалах яам, Эрчим хүчний яам, Эрүүл мэндийн яам, Эдийн засаг хөгжлийн яам, Терроризмтэй тэмцэх зөвлөл, Цөмийн шинжилгээний нэгдсэн институтын бүрэн эрхт төлөөлөгч, Шинжлэх ухааны Академич, Зэвсэгт хүчний жанжин штаб, Эвийн хүч эх нутгийн төлөө ТББ, Их бага баян шарга ТББ, Гамшгийн эсрэг үндэсний төв ТББ, Босоо Хөх Монгол ТББ зэрэг Монгол Улсын шийдвэр гаргах түвшний албан тушаалтнууд, төрийн байгууллага, судлаачид, Иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллүүд 64 байгууллагын 146 төлөөлөгч оролцсон байна.

Үйл ажиллагааны талаарх мэдээллийг 7 мэдээллийн хэрэгсэл олон нийтийн сүлжээ, 6 мэдээллийн сайт, 5 телевизээр цацаж, конвенц, протоколыг дэлгэрэнгүй танилцуулан, тэдгээрт нэгдэн орох ач холбогдол, үр нөлөөний талаар нэгдмэл ойлголт өгч, иргэдийг мэдэх эрхийг хангасан.

Энэхүү хэлэлцүүлгийн үр дүнд Монгол Улсын төрийн байгууллага, судалгаа шинжилгээний байгууллага, мэргэжлийн холбоод болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүд гэрээ, конвенциудын талаар ОУАЭА-ийн цөмийн аюулгүй ажиллагаа (safety), цөмийн аюулгүй байдал (security), цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгаа (safeguards)-ны асуудлаар мэргэшсэн хуульчдаас үнэн зөв, бодит мэдээлэл, ойлголт авч, Монгол Улс эдгээр олон улсын гэрээ, конвенцод нэгдэх орох үйл явцыг нэг алхмаар урагшлуулахад зэрэг үр дүн болсон.



Зураг 1. “Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгаа, цөмийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны олон улсын эрх зүйн хэрэгсэл” сэдэвт өндөр түвшний зөвлөгөөн



Зураг 2. “Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх баталгаа, цөмийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны холбогдолтой олон улсын конвенц, протоколд нэгдэн орохыг дэмжих нь” үндэсний хэлэлцүүлэг



Зураг 3. Монгол хэлнээ орчуулсан конвенц, протоколын танилцуулга

ОУАЭА-аас нийтэлсэн конвенц, протоколын дараах танилцуулгыг Монгол хэлнээ орчуулж, хэвлүүлэн олон нийтийн хуртээл болгосон. Үүнд:

- Цөмийн аюулгүй ажиллагааны олон улсын эрх зүйн орчин;
- Ашигласан түлшний цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай нэгдсэн конвенц;
- Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц ба 2005 оны Нэмэлт өөрчлөлт;
- Цөмийн аюулгүй байдлын хууль эрх зүйн орчин;
- Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааны хууль эрх зүйн орчин;
- Цөмийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны хууль эрх зүйн орчин;
- Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протокол;

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨ

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Үгүй	Ямар нэг сэргэг нөлөө үзүүлэхгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй	Ямар нэг сэргэг нөлөө үзүүлэхгүй
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Үгүй	Ямар нэг сэргэг нөлөө үзүүлэхгүй
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.2.Оролцоог хангах		
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгоходоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Үгүй	Ямар нэг сэргэг нөлөө үзүүлэхгүй
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Цөмийн материал хэрэглэгч аж ахуйн нэгж байгууллагууд
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн		
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Үгүй	Ямар нэг сэргэг нөлөө үзүүлэхгүй

	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх		Үгүй	Хүний эрх хязгаарлах, хөндөх асуудал гарахгүй учраас шаардлаггүй.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		Үгүй	Хүний эрх хязгаарлах, хөндөх асуудал гарахгүй учраас шаардлаггүй.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх		Үгүй	Хүний эрх хязгаарлах, хөндөх асуудал гарахгүй учраас шаардлагагүй.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
3. Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй

				Төрийн эрх бүхий байгууллага нь Шинэчилсэн протоколд манай улс нэгдсэн орсноос хойш Баталгаанд хамаарах бүх цөмийн материалын анхны тайланг 30 хоногийн дотор Олон улсын атомын энергийн агентлагт хүргүүлэх үүрэгтэй. Цөмийн матриал хэрэглэгч ААНБ-үүд цөмийн материалын бүртгэл тооллого хийж, эрх бүхий байгууллагад тайлагнах үүрэгтэй.
4. Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		
5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх 5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нелөө үзүүлэхгүй
			Үгүй	Ямар нэг сөрөг нелөө үзүүлэхгүй

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НЕЛӨӨ

Үзүүлэх үр	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нелөө үзүүлэх эсэх		Үгүй
			Үгүй
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нелөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдхөйг оролцуулан)		Үгүй
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нелөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нелөөлж чадах эсэх		Үгүй
	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй

	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
3. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
4. Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм		Хэрэгжилтийн тайланг гаргана
5. Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
6. Инновацийн болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
7. Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй

	7.4.Хувь хүний/гэр булийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
8. Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
9. Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
10. Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
11. Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуйж, Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааг олон улсын хэм хэмжээнд нийцүүлнэ.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Ажил эрхлэлтийн байдал,	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх		Үгүй

хөдөлмөрийн зах зээл	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр өрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил өрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
2. Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
3. Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
4. Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм		Хэрэгжилтийн тайланг жилд нэг удаа ОУАЭА-т хүргүүлж, хэлэлциүүлнэ.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй

	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдал нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
5. Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллопт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
6. Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
7. Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
8. Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
2. Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	2.2.Эрчим хүчиний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	2.3.Эрчим хүчиний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
3. Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
4. Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцэд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
5. Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
6. Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй

7. Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохицой ашиглах эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй

ТАВ. ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протокол нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, холбогдох бусад хууль тогтоомжтой уялдсан болно.

Шинэчилсэн протоколд нэгдэн орохтой холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

ЗУРГАА. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Монгол Улсад цөмийн технологийг энхийн зорилгоор эрүүл мэнд, геологи, уул уурхай, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, аюулгүйн үзлэг шалгалт, боловсрол шинжлэх ухааны зэрэг олон салбарт үр дүнтэй ашиглаж байна.

Монгол Улс 1972 оноос хойш Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай гэрээ, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц, Цөмийн ослыг шуурхай мэдээлэх тухай конвенц, Цөмийн осол гарсан буюу цацрагийн аюултай байдал бий болсон тохиолдолд тусlamж үзүүлэх тухай конвенц, Цөмийн террорист үйлдлийг хориглох тухай олон улсын конвенц зэрэг цөмийн энергийн чиглэлээр олон улсын хэд хэдэн гэрээ, конвенцод нэгдэн орсон бөгөөд эдгээр гэрээ конвенцын хүрээнд олон улсын өмнө хулээсэн үүргээ амжилттай биелүүлсээр байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат 1992 онд цөмийн зэвсэггүй бүсийн статустай болох Монгол Улсын санаачилгыг НҮБ-ын индэр дээрээс танилцуулж, холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний үр дүнд 2012 онд НҮБ-ын Аюулгүй зөвлөлийн гишүүн таван орон Монгол Улсын цөмийн зэвсэггүй бүс статусыг албан ёсоор баталгаажуулсан.

Монгол Улсын Их хурал 2015 онд “Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай” 60 дугаар тогтоолын 1 дүгээр хэсгийн 3-т Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, **Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд тус тус нэгдэн орох үүргийг Монгол Улсын Засгийн газарт өгсөн.**

Монгол Улс олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орохтой холбоотой асуудлаар Монгол Улсын шийдвэр гаргах түвшний албан тушаалтнууд, төрийн байгууллага, судлаачид, Иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллүүдэд гэрээ, конвенциудыг танилцуулах, нэгдэн орох ач холбогдол, үр нөлөөний талаар нэгдмэл ойлголтыг өгөх улмаар Монгол Улс эдгээр олон улсын гэрээ, конвенцод нэгдэх орох, дагаж мөрдөхөд Засгийн газрын үүрэг болон иргэний нийгмийн оролцоог дэмжуулэх зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ), Гадаад харилцааны яам (ГХЯ),

“Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгаа, цөмийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны олон улсын эрх зүйн хэрэгсэл” сэдэвт өндөр түвшний зөвлөгөөн “Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх баталгаа, цөмийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны холбогдолтой олон улсын конвенц, протоколд нэгдэн орохыг дэмжих нь” сэдэвт үндэсний хэллэлцүүлгийг 2023 оны 06 дугаар сарын 27-29-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсан.

Тус үйл ажиллагаанд ОУАЭА-ийн Хууль, эрх зүйн газар, Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааны газар, Цөмийн аюулгүй байдлын хэлтэс, Цөмийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын газар, Цацрагийн үүсгүүр, тээвэрлэлт, хаягдлын аюулгүй ажиллагааны хэлтэс, Цөмийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын газар, Монгол Улсын Ерөнхий сайдын төлөөлөл, Улсын Их хурлын гишүүд, УИХ-ын гишүүдийн төлөөлөлч, УИХ-ын Тамгын газар, УАБЗ-ийн Стратегийн хэлтэс, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Гадаад харилцааны яам, Боловсрол соёл шинжлэх ухааны яам, Батлан хамгаалах яам, Эрчим хүчний яам, Эрүүл мэндийн яам, Эдийн засаг хөгжлийн яам, Терроризмийт тэмцэх зөвлөл, Цөмийн шинжилгээний нэгдсэн институтын бүрэн эрхт төлөөлөлч, Шинжлэх ухааны Академич, Зэвсэгт хүчний жанжин штаб, Эвийн хүч эх нутгийн төлөө ТББ, Их бага баян шарга ТББ, Гамшгийн эсрэг үндэсний төв ТББ, Босоо Хөх Монгол ТББ зэрэг Монгол Улсын шийдвэр гаргах түвшний албан тушаалтнууд, төрийн байгууллага, судлаачид, Иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллүүд 64 байгууллагын 146 төлөөллийг оролцуулсан.

Монгол Улсад зохион байгуулагдсан үйл ажиллагаа нь Монгол Улс олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орохтой холбоотой асуудлаар Монгол Улсын шийдвэр гаргах түвшний албан тушаалтнууд, төрийн байгууллага, судлаачид, Иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллүүдэд гэрээ, конвенциудыг танилцуулах, нэгдэн орох ач холбогдол, үр нөлөөний талаар нэгдмэл ойлголтыг өгөх, эдгээр олон улсын гэрээ, конвенцод нэгдэх орох, дагаж мөрдөхөд Засгийн газрын үүрэг болон иргэний нийгмийн оролцоог дэмжихэд ихээхэн хувь нэмрээ оруулсан үйл ажиллагаа болсон.

Монгол Улс нь цөмийн байгууламжгүй хэдий ч цөмийн тулшний циклийг бүхэлд нь хэрэгжүүлдэг, цөмийн зэвсэгтэй 2 гүрний дунд оршиж байdag газар зүйн онцлогтой. Монгол Улстай хиллэдэг ОХУ, БНХАУ-ын цөмийн байгууламжийн аюулгүй байдал нь тухайн улсын хяналтын байгууллага, мөн ОУАЭА-ийн нарийн чанд хяналтад байdag хэдий ч болзошгүй ослын үед манай улсад цацраг идэвхт бохирдол үүсгэх эрсдэлтэй юм.

Зүүн хойд азид цөмийн зэвсэгтэй орнуудын дунд оршдог Монгол Улс нь үй олноор хөнөөх зэвсгийг хориглох, зэвсэг хураах, цөмийн зэвсгээс ангижрах чиглэлд илүү их хүчин чармайлт гаргах хэрэгтэйг цохон тэмдэглэсээр ирсэн юм. Бид 1992 онд цөмийн зэвсэггүй бус гэдгээ албан ёсоор зарлан тунхагласныг өмнө тэмдэглэсэн билээ.

Орчин үед үүсээд байгаа цэрэг дайны нөхцөл байдал, улс орнуудын цөмийн зэвсгийн талаар баримталж байгаа бодлого дахь өөрчлөлт нь цөмийн аюулгүй байдал тэр дундаа цөмийн баталгааны асуудлыг онцгойлон авч үзэх шаардлагатайг энхийг эрхэмлэгч улс орнуудад сануулсаар байна.

ОУАЭА-ийн Удирдах зөвлөлөөс цөмийн төхөөрөмжгүй болон бага хэмжээний цөмийн материалтай улс орнуудыг “Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протокол”-д гарах үсэг зурах уриалга гарснаас хойш 19 жил өнгөрсөн байна. ОУАЭА-ийн Ерөнхий бага хурлын тогтоолд “Бага хэмжээний цөмийн материалтай бүх улс орнууд нь бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг хууль эрх зүйн үүднээс зөвшөөрөгдсөн даруйд анхны хувилбар бүхий

бага хэмжээний цөмийн материалаа өөрчилж, өөрийн цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааны арга хэмжээг зохих ёсоор хэрэгжүүлэхийг уриалсаар байна.

Монгол Улс бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон баталснаар цөмийн зэвсгээс анgid байх статусыг шинэ түвшинд гаргахтай холбоотой эрх зүйн чадамжийг бий болгож, Олон улсын хамтын нийгэмлэгийн улс орнуудын хэмжээнд нэр хүндээ дахин гаргаж ирэх, таатай боломж бүрдүүлэх юм.

Монгол Улсын цөмийн зэвсгээс анgid байх тухай статусыг цаашид урагшлуулан бэхжүүлэхдээ бүс нутгийн тогтвортой, аюулгүй байдлыг хангаж, Зүүн Хойд Азид аюулгүй байдлын яриа хэлэлцээ явуулах тухай Монгол Улсын санаачилгын нэг чухал хүчин зүйл болгож ажиллах, хөрш зэргэлдээ ОХУ, БНХАУ-ын цөмийн байгууламжийн талаар мэдээлэл авах, хилийн ойр байрлах цөмийн байгууламжийн эрсдэлд үнэлгээ хийх, хүн ам, байгаль орчныг хамгаалах, болзошгүй ослоос сэргийлэх, аюулгүй ажиллагааг сайжруулах, цөмийн материалын биет хамгаалалт, цөмийн террорист үйлдлээс урьдчилан сэргийлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар эдгээр зорилтуудад нийцсэн үндэсний эрх зүйн орчинг бий болгох, цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааг хэрэгжүүлэх, үр дүнтэй хяналтыг бий болгох зэрэг олон талын ач холбогдолтой юм.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Энэхүү тандан судалгааны 2 дугаар хэсэгт томъёолсон зорилгод хүрэхийн тулд 3 дугаар хэсэгт хуулийн төсөл боловсруулах шаардлагатай нь тогтоогдсон.

Мөн 4 дүгээр хэсэгт хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг судлахад сөрөг нөлөө гараагүй бөгөөд 5 дугаар хэсэгт зохицуулалтын хувилбарыг өмнөх шатуудад хийсэн судалгааны хүрээнд харьцуулан дүгнэхэд Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орон нь зүйтэй гэж үзэж байна.

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН АЖЛЫН АЛБА

2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр

Ашигласан эх сурвалж :

1. Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц
2. Монгол Улсын Их Хурлын 2009 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 45 дугаар тогтоолын хавсралт, Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого
3. Монгол Улсын Их Хурлын 2015 оны “Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай” 60 дугаар тогтоол
4. Хууль тогтоомжийн тухай хууль
5. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол
6. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн 1540 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах “Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө”